ЗУРАГ 5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2024 оны эхний 5 сарын байдлаар



# VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар өслөө. 2024 оны 05 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 3.3 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар өссөн байна.

ЗУРАГ 6.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар




Хэрэглээний үнийн индекс 2024 оны 05 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 9.5 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 1.0 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 1.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 2.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.8 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.8 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 3.2 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.3 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 1.4 хувиар тус тус өөрчлөлт орсон байна.

ХҮСНЭГТ 6.1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2024-V / 2023-V | 2024-V / 2023-XII | 2024-V / 2024-IV |
|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **105.6** | **103.3** | **100.7** |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 107.5 | 107.0 | 101.8 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 104.3 | 101.0 | 100.2 |
| Хувцас, бөс бараа, гутал | 104.5 | 101.2 | 99.8 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 105.7 | 101.7 | 100.5 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 105.4 | 103.1 | 100.5 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 108.1 | 102.3 | 100.0 |
| Тээвэр | 99.7 | 99.5 | 100.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 102.2 | 102.4 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 103.9 | 101.7 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 121.2 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 105.1 | 100.7 | 100.0 |
| Даатгал, Санхүүгийн үйлчилгээ | 102.3 | 102.3 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 114.1 | 100.3 | 100.1 |

Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон захууд болох Алтжин, Бөмбөгөр, Нарантуул-2, Хүчит шонхор захуудаас авсан барааны бүтээгдэхүүний дундаж үнэ.

ЗУРАГ 6.2 АЛТАН ТАРИА ДЭЭД ГУРИЛ, АТАР ТАЛХНЫ ҮНЭ, жил бүрийн 5 сард, төгрөгөөр




ХҮСНЭГТ 6.2. БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, жил бүрийн 5 сард

| Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | 2022 V | 2023 V | 2024 V |
|---|---|---|---|---|
| Алтан тариа 1-р зэрэг | кг | 1 400 | 2 242 | 2 398 |
| Атар талх | ш | 1 700 | 2 512 | 2 500 |
| Цагаан будаа | кг | 4 600 | 4 800 | 4 399 |
| Шар будаа | кг | 3 575 | 4 625 | 3 150 |
| Хонины мах /ястай/ | кг | 11 750 | 16 820 | 14 244 |
| Үхрийн мах /ястай/ | кг | 14 250 | 19 298 | 16 601 |
| Адууны мах | Кг | 11 000 | 14 800 | 13 976 |
| Тахианы гуя | кг | - | 16 620 | 8 615 |
| Сүү задгай | л | 2 500 | - | - |
| Хорхой ааруул | кг | 24 000 | 28 174 | 28 374 |
| Өндөг | ш | 440 | 540 | 650 |
| Ургамлын тос | л | 7 250 | 11 216 | 9 000 |
| Алим, кг | кг | 6 250 | 7 335 | 6 544 |
| Банана, шар | кг | 6 750 | 7 369 | 7 122 |
| Төмс | кг | 1 500 | 1 645 | 1 800 |
| Лууван | кг | 3 250 | 2 236 | 2 739 |
| Сонгино | кг | 2 500 | 4 743 | 2 379 |
| Элсэн чихэр | кг | 3 600 | 3 550 | 4 000 |
| Эдийн саван "Popular" | ш | 1 275 | - | - |
| Угаалгын нунтаг "OMO" | ш | 2 550 | 5 949 | 7 500 |
| Аяга, таваг угаагч шингэн, "Fairy" | ш | 4 150 | 4 373 | 5 899 |

ЗУРАГ 6.3 НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5  сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.4 НЭГ КГ ЛУУВАН, ТӨМСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.5 ШАТАХУУНЫ ҮНЭ, жил бүрийн 5 сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

$I_{ct}^{L}$ – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

*t* – тайлант үе

*i* – бараа, үйлчилгээ

*o* – суурь үе

$P_t^i$ - i барааны тайлант үеийн үнэ

$P_0^i$ – i барааны суурь үеийн үнэ

$Q_0^i$- i барааны суурь үеийн жин

# ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, 2024 оны эхний 5 сарын байдлаар

| Торгуулсан жолоочийн тоо | | | Торгуулсан нийт хэмжээ /сая,төгрөг/ | | |
|---|---|---|---|---|---|
| 2023 V | 2024 V | | 2023 V | 2024 V | |
| 51 145 | 38 298 | 25.1% ↓ | 1 409.0 | 623.9 | 55.7% ↓ |

## НИЙТ ЗӨРЧИЛ 38 298

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй. боловч тээврийн хэрэгсэл жолоодсон
354

Эгнээ байраа буруу эзэлсэн
1 135

Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон
2 831

Хориглосон нөхцөлөөр зогссон
7 722

Бусад
23 611



Хамгаалах бүс хэрэглээгүй
2 151

Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн
21

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнүедээ тээврийн хэрэгсэл жолоодсон
473

# VII. ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Зам тээврийн осол, зөрчил: Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2024 оны 5 дугаар сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 6839 зөрчил илрүүлж, 128 хүнд торгож, эрх хасах, 31 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 7.1 ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

| Торгууль | 2022 I-V | 2023 I-V | 2024 I-V |
|---|---|---|---|
| Торгуулсан хүний тоо | 31 439 | 51 145 | 38 301 |
| Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/ | 1 224 | 1 409 | 623.9 |

ХҮСНЭГТ 7.2 ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

| Зөрчлийн хэлбэр | 2022 I-V | 2023 I-V | 2024 I-V |
|---|---|---|---|
| **НИЙТ ЗӨРЧИЛ** | **21 873** | **52 439** | **38 298** |
| Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон | 1 207 | 1 245 | 473 |
| Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон | 209 | 440 | 354 |
| Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон | 912 | 3 287 | 2 831 |
| Хамгаалах бүс хэрэглээгүй | 459 | 2 155 | 2 151 |
| Хориглосон нөхцөлөөр зогссон | 4 282 | 15 517 | 7 722 |
| Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн | 7 | 10 | 21 |
| Эгнээ байраа буруу эзэлсэн | 386 | 1 306 | 1 135 |
| Бусад зөрчил | 8 688 | 28 479 | 23 611 |

# АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны эхний 5 сарын байдлаар

Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/




Боловсруулах аж үйлдвэр /сая төгрөг/




Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /сая төгрөг/



# VIII. АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 3.3[1] өссөн. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 5 дугаар сарын байдлаар 48009.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4882.7 (11.3%) сая төгрөгөөр өссөн. Үүнд: боловсруулах үйлдвэрлэлийн салбар 30351.3 (63.2%) сая төгрөгөөр, уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар 13351.1 (27.8%) сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 4306.6 (9.0%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 5 дугаар сарын байдлаар 30351.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 784.5 (2.5%) сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: хүнс ундааны үйлдвэрлэл 4826.7 (39.5%), бусад боловсруулах үйлдвэрлэл 1190.0 (14.7%), гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл 268.5 (22.1%) сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын 2024 оны 5 дугаар сарын борлуулалт 50427.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5335.9 (11.8%) сая төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолт 4226.7 (45.4%) өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| | **Салбар** | Нийт бүтээгдэхүүн | | | Өсөлт/Бууралт | | Бүтэц /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 V | 2023 V | 2024 V | Дүнгээр | Хувиар | |
| | | Мян.төг | | | | | |
| **Нийт дүн** | | **25 595 019.3** | **43 126 280.4** | **48 008 999.2** | **4 882 718.8** | **11.3%** | **100.0%** |
| 1 | **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **8 648 630.5** | **8 892 274.2** | **13 351 134.8** | **4 458 860.6** | **50.1%** | 27.8% |
| | Нүүрс | - | 467 928.8 | 401 200. | - 66 728.8 | -14.3% | |
| | Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт | 3,987,441.1 | 2 137 883.6 | 8 801 952.4 | 6 664 068.8 | 311.7% | |
| | Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт | - | | 142 240. | 142 240. | - | |
| | Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 4 661 189.4 | 6 286 461.8 | 4 005 742.4 | -2 280 719.4 | -36.3% | |
| 2 | **Боловсруулах аж үйлдвэр** | **14 112 187.8** | **31 135 790.2** | **30 351 294.4** | **- 784 495.8** | **-2.5%** | 63.2% |
| | Хүнс ундааны үйлдвэрлэл | 3 650 902.1 | 12 217 114.7 | 7 390 408.3 | -4 826 706.4 | -39.5% | |
| | Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл | 2 349 942.2 | 5 986 302.7 | 7 436 196.8 | 1 449 894.1 | 24.2% | |
| | Хувцас үйлдвэрлэл | 2 378 566.9 | 2 028 607. | 3 954 411.9 | 1 925 804.9 | 94.9% | |
| | Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | - | 1 212 533. | 944 004. | - 268 529. | -22.1% | |
| | Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа | 1 086 878.3 | 1 358 219. | 2 080 720.6 | 722 501.6 | 53.2% | |
| | Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл | - | 70 728.6 | 80 354.2 | 9 625.6 | 13.6% | |
| | Тавилга үйлдвэрлэл | 458 717.4 | 192 178.7 | 1 585 116.1 | 1 392 937.4 | 724.8% | |
| | Бусад боловсруулах үйлдвэрлэл | 4 187 180.9 | 8 070 106.5 | 6 880 082.5 | -1 190 024. | -14.7% | |
| 3 | **Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа** | **2 834 201.** | **3 098 216.** | **4 306 570.** | **1 208 354.** | **39.0%** | 9.0% |
| | Хог хаягдал цуглуулах, зайлуулах | 2 834 201. | 3 098 216. | 4 306 570. | 1 208 354. | 39.0% | |
| **Борлуулалтын орлого** | | **27 427 172.5** | **45 091 806.8** | **50 427 735.9** | **5 335 929.1** | **11.8%** | **105.0%** |

Энэ оны 5-р сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн уул уурхайн олборлох үйлдвэрлэл 13351.1 (27.8%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4458.9 (50.1%) сая төгрөг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 4306.6 (9.0%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1208.4 (39.0%) сая төгрөгөөр өссөн бол боловсруулах

үйлдвэрлэл 30351.3 (63.2%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 784.5 (2.5%) сая төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

| Салбар | 2022 V | 2023 V | 2024* V | 2024* Гадаад | 2024* V / 2023 V |
|---|---|---|---|---|---|
| | Сая.төг | | | | хувь |
| **Нийт дүн** | 8 099.7 | 11 233.7 | 27 427.2 | 2 517.8 | **144.2%** |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 3 603. | 3 732.2 | 8 642.6 | | **131.6%** |
| Боловсруулах аж үйлдвэр | 3 677.1 | 6 828.8 | 15 130.8 | 2 517.8 | **121.6%** |
| Ус хангамж, сувагжилтын систем | 819.6 | 672.7 | 3 653.8 | . | **443.2%** |

2024 оны 5-р сарын байдлаар уул уурхайн олборлох аж үйлдвэр 8642.6 сая, боловсруулах үйлдвэрлэл 15130.8 сая, ус хангамж, сувагжилтын систем 3653.8 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан байна.

ЗУРАГ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, салбараар, сараар, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёог ашиглан тооцно.

Тооцох аргачлал:

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum(\frac{Q_t}{Q_0}) \cdot W_0 \cdot 100$$

$Q_t$- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

$Q_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

$P_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

$W_0$- Жин

## НИЙТИЙН АЖ АХУЙ, 2024 оны 5 сарын байдлаар

ЦЭВЭРЛЭСЭН ЗАМ ТАЛБАЙ - 1 800 мян $м^2$

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО - 497.8 сая.төг

| Гэр хороолол | Албан газар |
|---|---|
| 448.0 сая.төг | 49.8 сая.төг |
| 90.0% | 10.0% |

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ



2023 V 6 367.5 мян.$м^3$

2024 V 10 635.9 мян.$м^3$

10 635.9 мян.$м^3$

| Гэр хороолол | Албан газар |
|---|---|
| 9 572.3 мян.$м^3$ | 1 063.6 мян.$м^3$ |
| 90.0% | 10.0% |

Дүүргийн хэмжээнд 2024 оны 5 сард 1800 мян.м2 талбай цэвэрлэж 10635.9 мян.м3 хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 497.8.сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 199.8 сая төгрөгөөр (67.0%)-иар өссөн үзүүлэлтэй байна.

# IX. НИЙТИЙН АЖ АХУЙ

Чингэлтэй дүүргийн хувьд нийт цэвэрлэгээний ажил, хог хаягдлыг Тохижилт үйлчилгээний байгууллага болон Найши ХХК нь хариуцаж ажилладаг.

Дүүргийн хэмжээнд 2024 оны 5 сард 1800 мян.м$^2$ зам талбай цэвэрлэж, 10635.9 мян.м$^3$ хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 4268.3 мян.м$^3$ (67.0%) өссөн байна.

Ажил үйлчилгээний орлого 497.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 199.8 сая төгрөгөөр (67.0%) өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилбал 90.0% гэр хорооллоос, 10.0%-ийг албан газраас олсон орлого ээлж байна.

ХҮСНЭГТ 22. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2024 оны 5 сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2022 V | 2023 V | 2024 V | Өсөлт бууралт (хувь) |
|---|---|---|---|---|---|
| Цэвэрлэсэн талбай | мян.м$^2$ | 1800.0 | 1800.0 | 1800.0 | - |
| Тээвэрлэсэн хог | мян.м$^3$ | 6 139.2 | 6 367.5 | 10 635.9 | 67.0% |
| Орон сууц | Тн | - | - | - | - |
| Гэр хороолол | тн | 5 525.2 | 5 730.8 | 9 572.3 | 67.0% |
| Албан газар | тн | 613.9 | 636.8 | 1 063.6 | 67.0% |
| Зам талбай | Тн | - | - | - | - |
| Ажил үйлчилгээний орлого | сая.төг | 287.3 | 298.0 | 497.8 | 67.0% |
| Зам талбай | сая.төг | - | - | - | - |
| Гэр хороолол | сая.төг | 258.6 | 268.2 | 448.0 | 67.0% |
| Орон сууц | сая.төг | - | - | - | - |
| Албан газар | сая.төг | 28.7 | 29.8 | 49.8 | 67.0% |

* Эх үүсвэр: Найши ХХК

# X. ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ: 2024 оны эхний 5 сард Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээ 33680 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7647 (29.4%) хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрлэлт, хүүхэд үрчлэлт, овог нэр өөрчлөх бүртгэл, иргэний үнэмлэх олгох бүртгэлүүд тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10.1 ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

| Үзүүлэлт | 2023 V | 2024 V | 2024 V / 2023 V |
|---|---|---|---|
| | Дүнгээр | | Хувь |
| **Нийт** | **26 033** | **33 680** | **29.4** |
| Шинэ төрсөн | 1 061 | 1 153 | 8.7 |
| Гэрлэлт | 343 | 280 | -18.4 |
| Гэр бүл цуцлалт | 137 | 156 | 13.9 |
| Хүүхэд үрчлэлт | 24 | 13 | -45.8 |
| Эцэг тогтоосон | 30 | 45 | 50.0 |
| Овог, нэр өөрчлөх | 90 | 48 | -46.7 |
| Шилжин ирсэн | 3 359 | 2 822 | -16.0 |
| Лавлагаа | 12 435 | 22 988 | 84.9 |
| Иргэний үнэмлэх олголт: | 8 554 | 6 175 | -27.8 |
| 16 нас хүрч шинээр авсан | 842 | 1 407 | 67.1 |
| Дахин олголт | 7 712 | 4 768 | -38.2 |

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

# ОНЦГОЙ БАЙДАЛ, 2024 оны эхний 5 сарын байдлаар



Онцгой байдлын хэлтэс нь 2024 оны эхний 5 сарын байдлаар нийт 161 гал түймэр, гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 70 тохиолдлоор буюу (30.3%)-иар буурсан байна.



<u>Онцгой байдал:</u> Онцгой байдлын хэлтэс нь 2024 оны эхний 5 сард үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт 161 гал түймэр гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 70 тохиолдлоор (30.3%) буурсан байна.

ХҮСНЭГТ 10.2. ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА  ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 оны эхний 5 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2023 V | 2024 V | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Дуудлагын тоо | Тоо | 231 | 161 | -30.3% |
| Гал түймэр | Тоо | 196 | 122 | -37.8% |
| Иргэд унтраасан гал түймэр | Тоо | 33 | 27 | -18.2% |
| Өөрөө унтраасан гал түймэр | Тоо | 2 | 6 | 3.0[1] |
| Худал дуудлага | Тоо | 2 | 6 | 3.0[1] |
| Ажилласан цаг | Цаг.мин | 579 | 5 553 | 9.6[1] |
| Ашиглагдсан ус | Тонн | 164 | 492.7 | 3.0[1] |
| Ашиглагдсан шатхуун /дизель/ | Литр | 1 641 | 3 476.3 | 2.1[1] |
| Ашиглагдсан хөөс | Литр | - | - | - |
| Зарцуулсан мөнгө | Сая.төг | 8.6 | 47.0 | 5.5[1] |
| Аварсан хүний тоо | Тоо | 121 | 256 | 2.1[1] |
| Унтраасан барилга байшингийн тоо | Тоо | 115 | 73 | -36.5% |
| Нийт өмч хөрөнгө | Сая.төг | 2240 | 17 388 | 7.8[1] |
| Амьсгалын бие даасан төхөөрөмж | Тоо | 98 | 505 | 5.2[1] |

[1]-Дахин их

* Эх үүсвэр:  Онцгой байдлын хэлтэс

# ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, 2024 оны эхний 05 сарын байдлаар



| | Эд хөрөнгийн бүртгэл | Газар | Газраас бусад |
|---|---|---|---|
| Үйлчилгээний тоо | 8 640 | 3 261 | 5 379 |
| Үйлчилгээний хөлс (мян.төг) | 212 565 | 28 298 | 184 266 |

ҮҮНЭЭС:



Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ: 2024 оны 05 сард Улсын бүртгэлийн хэлтэс нь 7 төрлийн үйлчилгээг нийт 17280 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 425.1 сая төгрөгийн хураамж авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан хүн 6476 (59.9%), үйлчилгээний хөлс 218.3 сая төгрөг буюу 1.1 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 10.3 ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, төрлөөр

| Үйлчилгээний төрөл | 2024 V | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эд хөрөнгийн бүртгэл | | Газар | | Газраас бусад | |
| | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (мян.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (мян.төг) | Үйлчилгээ-ний тоо | Үйлчилгээ-ний хөлс (мян.төг) |
| **Нийт** | **8 640** | **212 565** | **3 261** | **28 298** | **5 379** | **184 266** |
| Анхны бүртгэл | 735 | 1 789 | 170 | - | 565 | 1 789 |
| Өмчлөх эрх шилжих гэрээ | 1 691 | 33 760 | 676 | 13 508 | 1 015 | 20 252 |
| Барьцааны гэрээ | 5 135 | 172 236 | 1 897 | 12 500 | 3 238 | 159 736 |
| Бусад гэрээ | 13 | 100 | - | - | 13 | 100 |
| Бүртгэлд өөрчлөлт оруулах | 733 | 4 586 | 406 | 2 290 | 327 | 2 296 |
| Урьдчилсан тэмдэглэл | 8 | 10 | | | 8 | 10 |
| Лавлагаа хуулбар | 325 | 84 | 112 | | 213 | 84 |

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2024 оны 05 сард 10628 хүнд 11450 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 120 хүнээр буурсан бол, зарцуулсан зардал 3705.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 10.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, төрлөөр, эхний 5 сард

| Үзүүлэлт | 2023 V | | | 2024 V | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ |
| **Дүн** | **186** | **10748** | **7745** | **194** | **10628** | **11450** |
| Халамж үйлчилгээ | 6 | 384 | 2060.00 | 16 | 682 | 7000.0 |
| Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 38 | 1491 | 3288.00 | 36 | 443 | 1400.0 |
| Анхны тусламжийн сургалт | 39 | 1634 | 65 | 44 | 1097 | 300.0 |
| Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа | 7 | 646 | 240.00 | 21 | 691 | 300.0 |
| Гамшгийн тусламж | 1 | 20 | 1915.00 | 2 | 10 | 350.0 |
| Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа | 15 | 3933 | 50.00 | 17 | 3467 | 1020.0 |
| Донорын өдөрлөг, сурталчилгаа | | | | 6 | 2900 | 60.0 |
| Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 29 | 1068 | 50 | 9 | 267 | 20.0 |
| Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа | 51 | 1572 | 77.00 | 43 | 1071 | 1000.0 |

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 16 удаа зохион байгуулж 682 иргэн, анхны тусламжийн сургалт 44 удаа зохион байгуулж 1097 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээр сургалтыг 9 удаа зохион байгуулж 267 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 43 удаа зохион байгуулж 10628 иргэнийг тус тус хамруулсан байна.

<u>Захиргааны мэдээлэл:</u> Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний 5 сард 1556 иргэдээс өргөдөл, гомдол ирснээс 1442-г хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 94 нь шийдвэрлэх шатандаа хянагдаж, 20 нь хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл гомдлын 94.0 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна.

ХҮСНЭГТ 10.5. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2024 оны эхний 5 сарын байдлаар

| Ангилал | 2024 он | Үүнээс: | |
|---|---|---|---|
| | | Шийдвэрлэх шатандаа байгаа | Шийдвэрлэж хариу өгсөн |
| Нийт | 1556 | 94 | 1462 |
| Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв | 7 | - | 7 |
| Нутгийн захиргааны байгууллагууд | 907 | 62 | 838 |
| 1800-1200 дугаарын оператор | 120 | 11 | 106 |
| 11-11 төвөөс ирсэн | 499 | 21 | 478 |
| Гар утасны аппликэйшнээр ирсэн | - | - | - |
| Мессеж | - | - | - |
| E-Service | 6 | - | 6 |
| Facebook | - | - | - |
| Дижитал сити | 9 | - | 9 |
| Хороо бүртгэсэн | 8 | - | 8 |
| НМХГ тусгай дугаар | - | - | - |

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: ................................ /Д.МӨНХЗУЛ/

Танилцуулгыг нэгтгэсэн мэргэжилтэн: .............................. /Ш.НАРАНМИЖИД/